

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Б.Одбаатар

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн тэнхимийн профессор, доктор(Ph,D), дэд профессор цагдаагийн хурандаа

Хураангуй: Энэхүү нийтлэлээр цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхэд анхаарал асуудлын талаар судлан судлаачийн байр сууринаас дүгнэлт, санал дэвшүүлэн гаргахыг зорилоо.

Abstract: In this article, we aim to make conclusions and suggestions from the point of view of a researcher about the issues of concern in the implementation of the function of ensuring the internal security of the police organization.

Түлхүүр үгс: цагдаагийн байгууллагын аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, аюулгүй байдлын үндэс.

Keywords: police security, internal security, the basis of security.

Оршил

Аливаа байгууллагын оршин тогтнох үндэс өөрийн дотоод аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээ зөв тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх, алба хаагчдын ёс суртахуун, сахилга хариуцлагыг дээшлүүлэх явдал байдаг.

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийн хүрээнд хариуцсан нутаг дэвсгэрт иргэн, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, амар тайван, аюулгүй орчныг бий болгох, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог хангах, алба хаагчдын нийгмийн баталгааг хангах зэрэг олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлдэг төрийн тусгай чиг үүрэгтэй алба юм. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд “Цагдаагийн албаны тухай хууль”-ийг шинэчлэн батлагдаж цагдаагийн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнд томоохон

өөрчлөлт гарч үүнтэй уялдан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнд иргэд олон нийтийн итгэл дэмжлэгийг хүлээх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинжлэх ухааны ололт дэвшлийг үр бүтээлтэй ашиглах зэрэг томоохон ажлуудыг хийж хэрэгжүүлж байна. Гэвч сайн зүйлийн хажуугаар зарим үед засгийн тогтворгүй байдал, улс төрийн нөлөөллөөс шалтгаалан цагдаагийн удирдах бүрэлдэхүүний томилгоо зарим үед хэт туйлширч байгаагаас нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга, засаг дарга нарын хооронд хамтран ажиллахад үл ойлголцол, хүндрэл учирч байгаагаас нутгийн удирдлагаас хамтран ажиллаж чадахгүй нэрийдлээр удирдах албан тушаалтныг өөрчилдөг сөрөг хандлага бий болсон. Энэ нь цаашид цагдаагийн байгууллагын бие даасан байдал, дотоод аюулгүй байдлаа ханган хэрэгжүүлэх үйл ажиллагаанд сөрөг байдлыг бий болгож байна.

Цагдаагийн байгууллагын удирдлага, алба хаагчид байгууллагын аюулгүй байдлыг хангах, түүнд

нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тал бүрээс нь судалж эрсдэлийг бууруулах, саармагжуулах зэрэг ажиллагаанд нэгдсэн ойлголт байхгүй, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны чиглэлийг тус тусдаа өөрсдийн онцлогт тохируулан тодорхойлсон зэргээс нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа харилцан адилгүй байгаа нь энэ чиглэлээр нэгдсэн стандарт бий болгож нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага бий болсныг харуулж байна.

Үндсэн хэсэг

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн¹”, Цагдаагийн албаны тухай 14 дүгээр зүйлийн 14.1.3-д “цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авах, цагдаагийн албаны дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах²” гэж заасан. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3. дахь хэсэгт дотоод аюулгүй байдлыг “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшилийг

дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн” тодорхойлсон.

Иргэдийн амгалан тайван, айх аюулгүй аж төрөх, ажиллаж хөдөлмөрлөх нөхцөлийг бүрдүүлж гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах нь цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг юм.

Үндэсний аюулгүй байдлыг тогтолцоо буюу систем гэж үзвэл цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдал түүний бүрлэдхүүн хэсэг гэж ойлгож болно.

Цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх чадавхаас³ үндэсний аюулгүй байдал шууд хамааралтай. Улмаар энэхүү чадавхад нөлөөлөх сөрөг хүчин зүйлийг “аюул занал” хэмээн үзэх жишиг хандлага байна.

Сөрөг хүчин зүйлийг эх сурвалжаар нь 1. гадаад орчны; 2. дотоод орчны гэж ангилна. Эдгээр сөрөг хүчин зүйлүүд дангаар оршихгүй бөгөөд харилцан нөхцөлдсөн байдгаараа онцлогтой.

Цагдаагийн байгууллагын аюулгүй байдалд гадаад орчны зүгээс нөлөөлөх хүчин зүйлийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- улс төр, нийгмийн тогтворгүй байдал;
- эдийн засгийн хөгжлийн түвшин баян ядуугийн ялгаа;
- иргэд, хуулийн этгээдээс явуулж байгаа хууль бус үйл ажиллагаа;

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 он. №1. Монгол Улсын Үндсэн хууль.

² Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 он. №8. Цагдаагийн албаны тухай хууль.

³ Үүнд хүний нөөцийн, техник, хүч хэрэгсэлийн гээд олон хүчин зүйл багтана.

➤ гэмт хэрэг, зөрчлийн гаралт, нийгмийн сөрөг үзэгдлүүд;

➤ олон нийт, иргэдийн цагдаад итгэх итгэл, нэр хүнд;

➤ цагдаагийн алба хаагчийн эрх зүйн баталгаа хангалтгүй байх зэрэг нь цагдаагийн байгууллагын аюулгүй байдалд гадаад орчны зүгээс нөлөөлж буй хүчин зүйл юм. Цагдаагийн байгууллагын аюулгүй байдалд дотоод орчны зүгээс нөлөөлөх хүчин зүйлд:

➤ алба хаагчийн сахилга хариуцлага сул, гэмт хэрэг зөрчилд орох.

➤ хүний нөөцийн сонгох, томилох, сургаж дадлагажуулахад алдаа гарах.

➤ удирдах ажилтны манлайлал, хяналт сул байх нь сөрөг нөлөөтэй.

Цагдаагийн байгууллагын хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх чадавхад нөлөөлөх сөрөг хүчин зүйл буюу “аюул”-аас дараах аргаар урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг зохион явуулна. Үүнд:

Зураг 1.

Цагдаагийн байгууллагын аюулгүй байдалд нөлөөлөх сөрөг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэлбэр

Цагдаагийн төв байгууллагын удирдлагаас дотоод аюулгүй байдлын асуудалд онцгой анхаарч Цагдаагийн ерөнхий газрын даргын 2010 оны 351 дүгээр тушаалаар (код 113) анх удаа дотоод аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчинг бүрдүүлж, үүгээр нэр томьёог тодорхойлох, аюулгүй байдлыг хангах ерөнхий чиглэлийг тогтоосон¹. Үүнд:

Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдал – хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх,

нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бусад чиг үүргийг гадаад, дотоод орчны нөлөөлөх хүчин зүйлээс үл хамааран үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангагдсан байдал;

Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах – цагдаагийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны сөрөг хүчин зүйлс нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, учруулж буй хор уршгийг саармагжуулахад чиглэсэн удирдлага, зохион байгуулалт, биет болон инженер техникийн арга хэмжээний цогц гэж тодорхойлжээ.

Хүний нөөцийн аюулгүй байдлыг хангах. Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн удирдлага нь цагдаа, дотоодын цэргийн байгууллагад анх ажиллах иргэнийг судлах, шилж сонгох, ажлын байранд томилох, сургах, дэвшүүлэх, алба хаагчийн ёс зүйг төлөвшүүлэх, хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаа юм.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 03 сарын 20-ны өдрийн 6/164 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-т цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл, түүнчлэн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхэд гадаад болон дотоод орчны зүгээс нөлөөлөх давуу ба сул тал, боломж ба учирч болох эрсдэл зэргийг тодорхойлон гаргажээ. Тухайлбал, энэхүү бодлогын баримт

¹ Журмын зорилго цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлын төрөл, нэр томьёог тодорхойлох, түүнийг хангах орон тооны бус

ажлын хэсэг ажиллах журмыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

бичгийн 2.1. дэх хэсэгт цагдаагийн тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар байгууллагын хүний нөөцийн тодорхойлсон байна.

Хүснэгт 1.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

	ХҮНИЙ НӨӨЦИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ
1	Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлж, түүнд тулгуурлан бодлогыг тодорхойлох, хүний нөөцийг бүрдүүлэх.
2	Хүний нөөцийн мэдээллийг удирдлагын шийдвэр гаргах хэрэгсэл болгох.
3	Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх сургалт, хөгжлийн бодлого боловсруулан хэрэгжүүлж, суралцагч байгууллага болох.
4	Карьер хөгжлийн болон цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог ажлын бүтээмжийг дээшлүүлэх хөшүүрэг болгох.
5	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх хэрэгсэл болгох.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тулгарч болзошгүй эрсдэлд гадаад орчны зүгээс “төр, бизнесийн бүлэглэлийн нэгдэл улс төрийн нам, эвслийн хүрээнд бий болж эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн, улс төрийн томилгоо нь цагдаагийн байгууллагын удирдлагын үйл ажиллагаанд нөлөөлж, улмаар бие даасан, хараат бус байдал алдагдах эрсдэл” үүсэх аюул байгааг тогтоосон байна.

Нөгөө талаар цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн статистик судалгаагаар 2015-2020 онд 326 алба хаагч 291 гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь жилд дунджаар 58,2 сард 4,8 гэмт хэрэгт шалгагдсан байна. Мөн дээрх хугацаанд давхардсан тоогоор 10061 цагдаагийн алба хаагч 10017 сахилгын

зөрчил гаргаж шалгагдсан нь жилд дунджаар 2003, сард 167, өдөрт 5,5 алба хаагч сахилгын зөрчил гаргасан байна¹.

Цагдаагийн алба хаагчдаас гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд холбогдох нь нэг талаас алба хаагчийн өөрийн ёс зүй, мэдлэг, ур чадвар сул байгаатай холбоотой боловч, нөгөө талаас анхан болон дунд шатны удирдах албан тушаалтны манлайлал, тэдний удирдан чиглүүлэх арга барил, гүйцэтгэлийн хяналт сул байгаатай шууд холбоотой гэж үзэхээс өөр аргагүй. Энэ талаар цагдаагийн байгууллагын “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг²”-ийн 2.2 дахь хэсэгт “дунд шатны удирдлагын менежмент сул, ур чадвар дутагдалтай” гэж дүгнэсэн байна³.

Эндээс дүгнэхэд шат шатны удирдах ажилтны үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, тэднийг бэлтгэх, сургах,

¹ Цагдаагийн ерөнхий газар. Дотоод хяналт, аюулгүй байдлын газар. Судалгаа, дүн шинжилгээний төв. Цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, харилцаа, ёс зүйн өнөөгийн байдал. судалгааны ажлын тайлан. 2020.

² Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015.03.20-ны өдрийн 6/169 тушаалын хавсралт.

³ Цагдаагийн ерөнхий газар. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон цагдаагийн алба хаагчдын өнөөгийн байдал. судалгааны ажлын тайлан. 2016.

томилоход бодлогоор хандах шаардлага бий болсон нь харагдаж байна. Иймд цагдаа, дотоодын цэргийн байгууллагад орчин үеийн менежментийн чиг хандлага, удирдлагын шилдэг арга барилыг нэвтрүүлэх замаар алба хаагч, шат шатны удирдах ажилтныг бэлтгэх, сургах, тэдний мэргэжлийн болон зохион байгуулах ур чадварыг хөгжүүлэх, манлайллыг дээшлүүлэх зайлшгүй шаардлага бий болоод байна.

Өнөөдөр төрийн тусгай чиг үүрэгтэй аль ч байгууллагад алба хаагчдыг сонгон шалгаруулах, томилох үйл явц тодорхой бус, үүнд нэгдсэн бодлого, төлөвлөлт байхгүйн улмаас зарим тохиолдолд хүний нөөцийн бодлого алдагдах, албан тушаал дэвших, сонгон шалгаруулалт гэхээсээ илүү үзэмжээр хандах явдал ажиглагдах болсон. Түүгээр ч барахгүй удирдлага солигдох бүрд доод тушаалын алба хаагчид солигдох ёстой мэт сөрөг үзэгдэл бий болж, зарим тохиолдолд энэ нь байх ёстой, хэвийн үзэгдэл мэт ойлгогдох хэмжээнд хүрсэн байна. Иймд цагдаа, дотоодын цэргийн байгууллагад орчин үеийн менежментийн чиг хандлага, удирдлагын шилдэг арга барилыг нэвтрүүлэх замаар алба хаагч, шат шатны удирдах албан тушаалтныг бэлтгэх, тэднийг сургах, давтан сургах, мэргэшүүлэх сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, сургалтын болон хичээлийн хөтөлбөрийг эрэлт,

хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах зайлшгүй хэрэгцээ шаардлага ч үүссэн байна.

Алба хаагчийн аюулгүй байдлыг хангах. Цагдаагийн байгууллага алба хаагчдынхаа аюулгүй байдлыг хангах, сахилга, ёс зүй, хариуцлагыг сайжруулах зорилгоор улирал бүр сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг зохион байгуулж, алба хаагчдаас гаргасан санал хүсэлтийг хүлээн авч тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. Төв, орон нутгийн цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд алба хаагчдыг албан үүргээ гүйцэтгэж байгаатай холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон түүний гэр бүлийн гишүүдийн хууль ёсны эрх ашгийг зөрчсөн үйлдэл буурахгүй байна. Энэ талаар алба хаагчдын дунд явуулсан санал асуулгын судалгаагаар 50-иас илүү хувь нь албан үүргээ гүйцэтгэж байхдаа их, бага хэмжээний халдлагад өртөж байгаа судалгаа гарсан байна¹. Иймд удирдлагын зүгээс ямар нэг халдлага, зөрчилд өртөж байгаа алба хаагчдын асуудлыг нэг бүрчлэн шалгаж буруутай этгээдэд зохих ёсны хариуцлага ногдуулж ажиллах нь алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, сэтгэл зүйн дэмжлэг болох учиртай. Алба хаагчдаас гэмт хэрэг, сахилга, ёс зүйн зөрчилд өртөх нь буурахгүй байгаад дүн шинжилгээ хийхэд алба хаагч цаг үеийн нөхцөл байдлыг зөв үнэлж

¹ Цагдаагийн ерөнхий газар. Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтэс. Гарын авлага. – УБ., 2019.

дүгнэх чадвар сул, харилцааны ур чадвар, соёлд суралцаагүй, аюулгүй байдлаа хангах мэдлэг сул байгаатай холбоотой. Түүнчлэн алба хаагч үйл ажиллагаандаа

“Цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээний стандарт”-ыг хэрэгжүүлж хэвших, хуулийг дээдлэх хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэх, иргэдтэй соёлтой харьцаж үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах, алба хаагч нэг нэгэндээ хүндэтгэлтэй хандаж байх зэрэг гол, гол үзүүлэлтээр алба хаагч бүрээр баталгаа гаргуулан аюулгүй байдлыг

хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа ч дутагдал, зөрчил гарсаар байгаа нь ажлын хариуцлага сул байгаатай холбоотой. Ер нь алба хаагчийн аюулгүй байдлыг аливаа аюул занал учрах нөхцөл үүсэхээс бүрэн сэргийлж, урьдчилан тооцоолон, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бий болгох, бүрдүүлэх гэж ойлгож болно.

Тэгвэл алба хаагчийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл байдлын дараах ангилал, бүлэгт авч үзэж болно.

Зураг 2.

Алба хаагчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны чиглэл



Эдгээр нөхцөл байдал бүрэн хэмжээнд хангагдсан үед алба хаагчийн аюулгүй байдал хангагдсан гэж үзэж болох юм.

Алба хаагчийн хууль, эрх зүйн аюулгүй байдал. Алба хаагчийн эрүүл мэнд, эдийн засгийн хараат бус байдал болох цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн баталгаа, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломж, хөдөлмөрийн аюулгүй үйл ажиллагааны хамгаалалт, сэтгэл санаа

бие, эрүүл мэндийн аюулгүй байдал хэрхэн хангагдсан буюу албан үүргээ гүйцэтгэж байгаад болон гүйцэтгэсэнтэй нь холбогдуулан халдсан, хохирол учруулсан тохиолдолд хэрхэн хамгаалах, учирсан хохирлыг барагдуулах, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх гэх мэт асуудлыг хууль эрх зүйн актад тусгасан тухай асуудал багтана. Цагдаагийн төв байгууллага Цагдаагийн албаны

хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3. дахь хэсэгт зааснаар цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авах, цагдаагийн албаны дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах үүрэгтэй бол, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь хэсэгт зааснаар байгууллага, алба хаагч, ажилтны аюулгүй байдлыг хангах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүрэгтэй.

Алба хаагчийн эдийн засгийн аюулгүй байдал. Өнөөдөр цагдаагийн алба хаагч хуулиар хүлээсэн албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа эдийн засгийн хараат бус байдал хангагдаагүй нөхцөлд бусдын эрх ашигт нийцсэн хууль бус шийдвэр гаргаж болзошгүй байгаа нь өөрөө аюултай нөхцөл байдлыг үүсгэж байгаа юм. Ер нь цагдаагийн алба хаагчийн эдийн засгийн аюулгүй байдлыг дотор нь үндсэн хоёр хэсэгт системчлэн шалгуур үзүүлэлт тогтоон авч үзэх боломжтой юм. Үүнд:

1. Алба хаагчийн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах шалгуур үзүүлэлт;

2. Үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж буй эдийн засгийн шалгуур үзүүлэлт.

Дээрх хоёр чиглэлийн шалгуур үзүүлэлт нь хэдийгээр тус тусдаа ойлголт мэт боловч аль нэгийг нь бүрэн хангахгүйгээр тэдний эдийн засгийн аюулгүй байдлыг баталгаатай хэмжээнд хангасан гэж үзэх нь өөрөө учир дутагдалтай.

Алба хаагчийн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах шалгуур

үзүүлэлтэд түүнд төрөөс өгч байгаа цалин хөлс, бусад нэмэгдэл байгууллагын зүгээс өгч буй эдийн засгийн тусламж дэмжлэг зэрэг хувь хүний амьдралд шууд нөлөөлж буй материаллаг зүйлийг оруулж болно. Цалин хөлс, нэмэгдэл ажилласан жилээс хамааран ялгавартай байдаг. Харин байгууллагаас өгч буй тусламж дэмжлэгт алба хаагчдаа зориулж орон сууц барих, байгууллага, төрийн зардлаар гадаад, дотоодын мэргэжлийн сургалтад хамрагдах зэрэг тусламж, дэмжлэг явуулсаар байгаа нь тэдний эдийн засгийн баталгааг хангахад зохих үр дүнгээ өгч байна.

Үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж буй эдийн засгийн шалгуур үзүүлэлтэд хуульд заасан хэрэгжүүлэхэд гарч буй зардлыг төрөөс хэрхэн хангаж байгаа, түүний хүртээмжийн тухай асуудал багтана.

Сэтгэл зүйн аюулгүй байдал.

Ажлын ачааллаас алба хаагч сэтгэл санааны хувьд стресст орох, уур бухимдалтай болох, ажлын бүтээмж буурах болон гэр бүлдээ анхаарал халамж тавих байдал сулрах зэрэг байдлаар сэтгэл зүйн өөрчлөлтүүд гарсаар байна. Энэ нь нэг талаас алба хаагчийг бэлтгэхдээ мэргэжлийн чиглэлийн хичээлээр мэргэшүүлэн бэлтгэж, харин сэтгэл зүйн хувьд өөрт болон бусдад учирсан стресс, сэтгэл санааны дарамт, бухимдлыг хэрхэн гаргах талаар зааж сургадаггүй зөвхөн хувь хүний хүмүүжил, ажлын туршлагаараа л сэтгэл зүйн асуудлаа шийдвэрлэсээр өдийг хүрсэнтэй холбоотой. Мөн алба хаагчийн сэтгэл санааны бухимдал, стрессийг зөвөөр гаргах нөхцөл боломж хараахан бүрдээгүй байна.

Алба хаагчид сэтгэл зүйн засал, зөвлөгөө өгөх талаар тодорхойлсон боловч хэрэгжихгүй байгаа нь үндсэн

чиг үүргээ шуурхай явуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад төдийлөн анхаарал хандуулахгүй байгаагийн нэг жишээ юм.

Бие, эрүүл мэндийн аюулгүй байдал. Ажлын ачаалал ихтэйгээс болоод хүний амарч, ажиллах цаг, хооллох дэглэм алдагдаж биед өвчин үүсэх үндсэн нөхцөл болж байна. Иймд алба хаагчийн бие бялдрыг хөгжүүлэхэд тусгай хөтөлбөрт үйл ажиллагаа явуулах нь нэг талаас эрүүл мэндийг анхаарч байгаа төдийгүй нөгөө талаас бие бялдрын аюулгүй байдлыг хангаж байгаа хэлбэр юм.

Энэ талаар ч мөн хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн бөгөөд “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ын 932 дугаар зүйлийн 932.2.1. дэх хэсэгт:

➤ алба хаагчийн тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад улсын эмнэлгийн байгууллагад эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд эмнэлгийн байгууллагын дүгнэлт, холбогдох бусад баримтыг үндэслэн эмчилгээний зардлын 60-аас доошгүй хувийг;

➤ алба хаагч биеийн эрүүл мэндийн байдлын улмаас 1 жилээс дээш хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон, цагдаагийн байгууллагын шийдвэрээр (*захиалгаар*) гурван сараас дээш хугацааны сургалтаар (*шинэ дадлага, туршлага эзэмших сургалтыг оролцуулан*) бэлтгэгдэх болсон, цэргийн алба хаах болсон, Гэрч, хохирогчийг хамгаалах

тухай хуулийн дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан тохиолдолд 3 сар хүртэлх цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг олгож болно гэж заасан байна.

Үйл ажиллагааны аюулгүй байдал. Үйл ажиллагааны буюу хөдөлмөрийн аюулгүй байдал гэж хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байхыг хэлнэ¹ гэж хуульчилсан байх бөгөөд цагдаагийн алба хаагч нь төрд алба хааж хөдөлмөрлөж буй субьектийнхээ хувьд хамгаалуулсан байх нь ойлгомжтой.

Цагдаагийн байгууллагын эрсдэлийн үнэлгээний 2019, 2020 оны тайланд цагдаагийн алба хаагч албан үүрэг гүйцэтгэж байхдаа гүтгүүлэх, доромжлуулах, хүчирхийлэл, заналхийлэлд өртөх эрсдэл “5” буюу өндөр үнэлгээтэй гарч, цагдаагийн байгууллага дахь эрсдэл бүхий ажлын байрны жагсаалтыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамд хүргүүлсэн байна².

Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаарын тушаалын хавсралтын 1.4. дэх хэсэгт “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийхэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ MNS 5080:2001” стандарт,

¹ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2008 он. №21.

² Цагдаагийн ерөнхий газар. Эрсдэлийн үнэлгээний тайлан. – УБ., 2020.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин., Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015” стандартыг мөрдлөг болгоно” гэж тогтоожээ. Эдгээр стандарт шаардлагад ажиллах орчны халуун дулаан, гэрэлтүүлэг, хэт өндөр дуу чимээ, агаарын орчны хорт бодисын зөвшөөрөгдөх хэмжээ, сэтгэл зүй, физиологийн хүчин зүйлээр нь ангилж хөдөлмөрийн тохиромжтой, зөвшөөрөгдсөн, хортой аюултай түвшинд хуваан үзсэн байна. Гэтэл цагдаагийн алба хаагч олон нөхцөл байдалд явагддаг тул дээрх төрөл, түвшний аль нэгэнд шууд хамааруулан үзэх боломжгүй байгаа нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад төвөгтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Гурав. Мэдээллийн аюулгүй байдлын хангах. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь төр, байгууллагын нууц¹ алдагдвал байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, улмаар хүний нэр төр, алдар хүндэд халдаж болзошгүй мэдээ, сэлт, биет зүйлийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа юм.

Цагдаагийн албаны тухай хуулийн 6 дугаарын зүйлийн 6.6. дах хэсэг “цагдаагийн байгууллага харьяандаа чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэшсэн нэгж, мэдээлэл нэгтгэн боловсруулах, судалгаа, сургалт дадлагын, албаны зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанар стандартыг судлан тогтоох лаборатори болон инженер техник, засвар үйлчилгээ, үйлдвэрлэл, санхүү, хангалт, спорт, соён гэгээрүүлэх,

мэдээллийн технологи, аюулгүй байдал хариуцсан нэгжтэй байж болно²” гэж заажээ. Мөн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дахь хэсэгт зааснаар “Цагдаагийн байгууллага доор дурдсан тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан үүсгэн, үйл ажиллагаандаа ашиглана” гэж заасан бөгөөд одоо нийт 21 төрлийн мэдээллийн сан ашиглан, уг сангийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй ажиллаж байна.

Цагдаагийн байгууллага мэдээлэл, технологийн хөгжлөөс хоцрохгүй, шинэ техник, технологийг нэвтрүүлэх, мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангах талаар нэлээд ажлыг зохион байгуулсан. Цагдаагийн байгууллагын мэдээллийн систем нь бодлого, стратеги, хүний нөөц, программ хангамж, өгөгдлийн сан, техник хангамж гэсэн үндсэн хэсгээс бүрдэж байна. Цагдаагийн байгууллагын мэдээллийн систем, өгөгдлийн сангийн серверүүд, сүлжээний төхөөрөмжүүдийг нөөц тэжээлийн системд холбож серверүүдийн найдвартай, аюулгүй ажиллагаа сайжирч байна. Мөн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор албаны хэрэгцээнд ашиглаж байгаа компьютеруудыг нууц код, паспорттой болгож хэвшсэн ч ашиглалтын талаарх бүртгэлийг дутуу хөтөлж үйл ажиллагаа жигдрээгүй дутагдал байсаар байна.

Дөрөв. Санхүү /төсвийн хөрөнгө/-гийн аюулгүй байдлыг хангах. Санхүүгийн аюулгүй байдлыг хангах нь төсвийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, түүнийг зориулалтын бусаар зарцуулах,

¹ Байгууллагын нууц – хүний эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйл.

Байгууллагын нууцын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1995 он. №7

² Цагдаагийн албаны тухай хууль. 6 дугаар зүйл. **Цагдаагийн байгууллагын тогтолцоо.**

ашиглах, завших, үрэгдүүлэхээс сэргийлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаа юм.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсэг байгууллагынхаа төсвийн болон мөнгөн хөрөнгө, эд зүй, үнэт цаасны зарцуулалтын тооцоонд сар бүр тогтмол хяналт тавьж, гэнэтийн тооллого явуулан зөрчил, дутагдал илэрвэл засах ажлыг зохион байгуулж санхүүгийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой ажлуудыг явуулж байна. Тухайлбал, нийслэлийн цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсгээс дүүргүүдийн цагдаагийн газар, хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд тогтмол шалгалт хийж эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн төлбөр, үнэт цаасны тооцоог цаг тухайд нь хийдэггүй, дэлгэрэнгүй бүртгэл хөтөлдөггүй, дотоод ажлын уялдаа холбоо, хяналт шалгалт сул байгаа зэрэг зөрчлийг удаа дараа илрүүлэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна.

Дүгнэлт.

1. Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдалд гадаад болон дотоод орчны зүгээс дараах хүчин зүйл нөлөөлж байна гэж үзлээ. Үүнд:

Гадаад орчны зүгээс нөлөөлөх хүчин зүйл:

➤ улс төр, нийгмийн тогтворгүй байдал.

➤ эдийн засгийн хөгжлийн түвшин /баян ядуугийн ялгаа/.

➤ иргэд, хуулийн этгээдээс явуулж байгаа хууль бус үйл ажиллагаа.

➤ гэмт хэрэг, зөрчлийн гаралт, нийгмийн сөрөг үзэгдлүүд.

➤ олон нийт, иргэдийн цагдаад итгэх итгэл, нэр хүнд.

Дотоод орчны зүгээс нөлөөлөх хүчин зүйл:

➤ алба хаагчийн сахилга хариуцлага сул, гэмт хэрэг зөрчилд орох.

➤ хүний нөөцийн сонгох, томилоход алдаа гарах.

➤ удирдах ажилтны манлайлал, хяналт сул байх.

2. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дотоод аюулгүй байдалд гадаад орчны зүгээс нөлөөлөх хүчин зүйлийг:

➤ Political force буюу улс төрийн орчин

➤ Economic force буюу эдийн засгийн орчин

➤ Sociocultural force буюу нийгэм-соёлын орчин

➤ Technological force буюу техник-технологийн орчин

➤ Legal force буюу хууль, эрх зүйн орчин

➤ Environmental force буюу хүрээлэн буй орчин зэрэг хүчин зүйлээр цогц хэлбэрээр авч үзэн нөхцөл байдлаа бодитоор тогтоон үнэлж дүгнэж байх шаардлагатай байна.

Дэвшүүлэх санал.

1. Эрсдэлийн удирдлагыг бүх шатанд нэвтрүүлж эрсдэлээ бүрэн тодорхойлох, түүнийг бууруулах, саармагжуулахад чиглэсэн “Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө”-г боловсруулан жил бүр үр дүнг тооцож ажиллах.

2. Ажлын байрны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг тодорхой хөрөнгө, төсөв гарган шийдвэрлэн алба хаагчийн ажиллах

орчин нөхцөлийг сайжруулахад онцгой анхаарах.

Ашигласан эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992 он. №1.

2. Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 он. №8.

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2008 он. №21.

4. Байгууллагын нууцын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1995 он. №7

5. Цагдаагийн ерөнхий газар. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон цагдаагийн алба хаагчдын өнөөгийн байдал. судалгааны ажлын тайлан.

2016.

6. Цагдаагийн ерөнхий газар. Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтэс. гарын авлага. – УБ., 2019.

7. Цагдаагийн ерөнхий газар. Эрсдэлийн үнэлгээний тайлан. – УБ., 2020.

8. Цагдаагийн ерөнхий газар. Эрсдэлийн үнэлгээний тайлан. 2020.

9. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 6/169 тушаал. Хүний нөөцийн бодлогын баримт бичиг.

10.ЦЕГ-ын Дотоод хяналт, аюулгүй байдлын газар, Судалгаа, дүн шинжилгээний төв. Цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, харилцаа, ёс зүйн өнөөгийн байдал” судалгааны ажлын тайлан. – УБ., 2020.